

**АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР УУЛ УУРХАЙН САЛБАРТ  
АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

2016 оны 3 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

***Нэг. Зорилго***

Хөндлөнгийн шинжээчдийн багаас хийсэн “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны 2013, 2014, 2015 оны үнэлгээгээр Уул уурхайн яамны үзүүлэлт тодорхой ахицтай ч, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын 2015 оны үнэлгээ 21.1 оноогоор буурч үнэлэгдсэн, Австралийн засгийн газар, Азийн сангийн дэмжлэгтэйгээр Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн, МУИС-ийн багш судлаачдын багаас хамтран 2015 оны 9 дүгээр сард гүйцэтгэсэн “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын шалтгаан, нөхцөл” сэдэвт судалгааны дүнгээр уул уурхайн салбар авлигад өртөмтгий салбар гэж нэрлэгдсэн, “IRIM” судалгааны хүрээлэнгийн 2016 оны “Олборлох салбар дахь авлигын эрсдлийг бууруулах” судалгааны дүн зэрэгтэй холбогдуулан тус салбарын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг нь дээшлүүлэх, энэ чиглэлээр зөвлөх, арга зүйн удирдлагаар хангах.

***Хоёр. Ажиллах чиглэл***

2.1. Төрийн болон төрийн бус байгууллагаас явуулсан судалгаа, шинжилгээний дүнг танилцуулах ажлын хүрээнд:

2.1.1. Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2015 оны үнэлгээ дүн /”MDS and KhanLex” ХХН, “Хөгжлийн санаачилга бодлого судлалын төв” ТББ, 2015 он/;

2.1.2. Олборлох салбар дахь авлигын эрсдлийг бууруулах /IRIM судалгааны хүрээлэн 2016 он/;

2.1.3. Шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ, 2016 он/

2.1.4. “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын шалтгаан, нөхцөл” судалгааны дүн /”Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэн” ТББ, МУИС-ын багш нарын судалгааны баг, 2015 он/-г тус тус танилцуулна.

2.2. Авлигын эсрэг болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах, сургалт зохион байгуулах ажлыг зорилтод бүлэгт чиглүүлэн ажиллах хүрээнд:

2.2.1. төрийн албан хаагчдад;

2.2.2. иргэний нийгмийн байгууллагуудад;

2.2.3. уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд;

2.2.4. сурталчилгааны материал, гарын авлага түгээх;

2.2.5. хэлэлцүүлэг, ярилцлага өрнүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах;

2.2.6. төр, хувийн хэвшлийн байгууллагуудтай зөвлөлдөх уулзалт зохион байгуулах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллана.

2.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах, заавар зөвлөмж өгөх ажлын хүрээнд:

2.3.1. Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх, арга зүйн удирдлагаар хангах;

2.3.2. “Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-д тусгасан шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн заавар, зөвлөгөө өгөх;

2.3.3. уул уурхайн салбарт мөрдөгдөж буй дүрэм журам, зааврыг хянан үзэж, холбогдох арга хэмжээг авах;

2.3.5. иргэд, байгууллагаас тус салбарт холбогдох асуудлаар АТГ-т хандаж ирүүлсэн гомдол, мэдээллийн талаар судлан үзэх;

2.3.6. АТГ-ын мөрдөн байцаагчаас хүргүүлсэн “Мэдэгдэл”, зөрчил арилгуулах чиглэлээр хүргүүлсэн албан бичгийн мөрөөр холбогдох арга хэмжээг авах;

2.3.7. байгууллагын болон салбарын хэмжээнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг шинжлэн үзэж, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх ;

2.3.8. эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ныг мэдээлэл, арга зүйгээр хангах зэрэг болно.

2.4. Дээрх чиглэлээр төрийн байгууллагуудаас хийж буй үйл ажиллагаа, үр дүнг дээшлүүлэх, иргэд олон нийтэд хүргэх хүрээнд:

2.4.1. Удирдамжийн 2.1-2.3, 2.4.2-2.4.4-т заасан үйл ажиллагааны талаар байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулах;

2.4.2. хэвлэл мэдээллийнхэн, олон улсын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах;

2.4.3. дээд шатны байгууллага, удирдах албан тушаалтанд танилцуулах, анхаарах асуудлын талаар зөвлөгөө өгөх, арга зүйн удирдлагаар хангах;

2.4.4. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

### ***Гурав. Хамрах хүрээ***

3.1. Уул уурхайн яам, зохион байгуулалтын бүтцийн нэгж;

3.2. Ашигт малтмалын газар, зохион байгуулалтын бүтцийн нэгж;

3.3. Газрын тосны газар, зохион байгуулалтын бүтцийн нэгж;

3.4. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж;

3.5. Салбарын мэргэжлийн холбоо, ТББ-д.

### ***Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа***

4.1. 2016 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд ажиллана.

### ***Тав. Ажиллах бүрэлдэхүүн***

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан, ахлах комиссар Л.Батбаяр, ажилтан, комиссар Ж.Сарангэрэл, А.Дэлгэрбаяр, Б.Тэрбиш нар ажиллах ба ажиллах чиглэлийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн даргаар батлуулан явцын хэрэгжилтийг тухай бүрт нь тайлагнаж ажиллана.

### ***Зургаа. Тайлагнах***

Уул уурхайн салбарт ажилласан тухай тайланг илтгэх хуудсаар 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Газрын удирдлагад танилцуулна.

Танилцсан: Тамгын хэлтсийн дарга,  
эрхэлсэн комиссар

З.Баасанням

Хянасан: Урьдчилан сэргийлэх, соён  
гэгээрүүлэх хэлтсийн дарга  
эрхэлсэн комиссар

Б.Бат-Отгон

Боловсруулсан: Урьдчилан сэргийлэх, соён  
гэгээрүүлэх хэлтсийн ажилтан,  
комиссар

Ж.Сарангэрэл

төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгааны үр дүнгээр Боловсролын салбарын төрийн байгууллагын шударга байдлын түвшин 3.51 үнэлэгдэж, өмнөх судалгааны үр дүнгээс 0.03 пунктээр буурсан,